AND ENERGY




# АНД-ЭНЕРГИ ХУВЬЦААТ КОМПАНИ

# ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

**Утас:** 88351298, 77711010

**E-mail:** info.andenergy@gmail.com

ОРХОН АЙМАГ

AND ENERGY

АГУУЛГА

## 1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА


1.1. Ерөнхий танилцуулга ........ 3
1.2. Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааны зарчим ........ 4
1.3. Бүтэц, зохион байгуулалт ........ 4
1.4. Бүтэц зохион байгууллалтад гарсан өөрчлөлтүүд........ 5
1.5. Сургалт хөгжил ........ 6


## 2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


2.1. Онцлох үйл явдлууд........7-8
2.2. Гэрэлтүүлгийн үйлдвэрлэл ба үйл ажиллагаа ........9-15
2.3. Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд........ 16-20


## 3. БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА


3.1. MEIYUN LIGHTING брэндийн шинэ загварын гэрэлтүүлгийн худалдаа........ 21
3.2. Гэрэлтүүлгийн салбарын тухай........ 22
3.3. Бүтээгдэхүүн ........23
3.4. Бидний харилцагчид........ 24


## 4. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


4.1. Засаглалын тогтолцоо........25
4.2. Хувьцаа эзэмшигчид........26
4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал........26
4.4. Төлөөлөн удирдах зөвлөл........27-29
4.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа........30-32
4.6. Хөрөнгийн зах зээл, хувьцааны арилжаа........33


## 5. САНХҮҮГИЙН ТАЙЛАН


5.1. Санхүүгийн байдлын тайлан ........34-35
5.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан........36
5.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан........37
5.4. Мөнгөн гүйлгээний тайлан........38

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| КОМПАНИЙН ОНООСОН НЭР | Анд-Энерги ХК |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ | - LED гэрэл, гэрэлтүүлгийн үйлдвэрлэл<br>- Цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ<br>- Үйлдвэрлэлийн автоматжуулалт<br>- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |
| АЛБАН ЁСНЫ ХАЯГ | Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян-Зам 3-4, 6 тоот<br>Утас: 77711010<br>И-мэйл: Info.andenergy@gmail.com<br>Веб сайт: www.andenergy.mn<br>Фейсбүүк: And energy |
| КОМПАНИЙН УДИРДЛАГА | ТУЗ-н дарга: Төмөрбатын Барс<br>Гүйцэтгэх захирал: Цэнд-Аюушийн Гүррагчаа |
| ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО | 2011 оны 5-р сарын 23 өдөр |
| АЖИЛЧДЫН ТОО | 31 |
| ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ | Өдөрт 500-800 гэрэл үйлдвэрлэх |
| ДЭЛГҮҮРИЙН ТОО | Орхон аймаг-1: Үйлдвэрийн байранд<br>Улаанбаатар хот-1: Мишээл Барилгын Их дэлгүүрийн2 давхарт 87-р павильон |

## 1.2. ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ




## 1.3. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2022 онд нийт 36 хүн ажиллах бүтцийн орон тоотойгоор бизнес төлөвлөгөөнд тусган баталж, одоогийн байдлаар 31 хүн ажиллаж байна.



## 1.4 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Компанийн үйл ажиллагааны зан төлөвт тохирсон хүний нөөцийг бүрдүүлэх, сургажхөгжүүлэх замаар мэргэшсэн менежментийн болон ИТА-г бий болгон, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Ажилчдын мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, өсөн дэвших боломжийг бүрдүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цахим хэлбэрээр сургалтуудад хамруулж байна.
- Ажлын үзүүлэлтийг үнэлэх журмын дагуу бүтээмжид суурилсан нэмэлт урамшууллыг олгож байна.
- Судалгаа хөгжлийн багийг шинээр бүрдүүлж, бүтээгдэхүүн хөгжүүлэх, хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинээр үндэсний өв соёлыг хадгалсан бүтээгдэхүүн бий болгохоор ажиллаж байна.
- Бид ажилтнаа тогтвор суурьшилтай, урт хугацаанд бүтээмжтэй ажиллуулах, нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор удаан жил ажилласны нэмэлт урамшуулал, ур чадварын нэмэгдэл цалинг олгож эхлээд байна.
- 2022 оны бизнес төлөвлөгөөний хүрээнд дараах схемийн дагуу хүний нөөцийн бүрдүүлэлт хийхээр төлөвлөн ажиллаж байна.



## 1.5 СУРГАЛТ ХӨГЖИЛ

2022 оны 1 дүгээр хагас жилд ажилчдаа чадваржуулах зорилгоор дараах сургалтуудад хамруулсан.

- ✓ GIZ төслийн "Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх цуврал сургалт"-д 1 ажилтан;
- ✓ Монгол-Японы хөгжлийн төвийн "Хүний нөөцийн менежментийн талаарх ойлголт, төлөвлөлт, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, идэвхжүүлэлт"сэдэвтэй сургалтад 1 ажилтан;
- ✓ Жолооны С ангилал олгох сургалтад 2 ажилтан;
- ✓ Сагстай өргөгчийн операторын сургалтад нийт 3 ажилтан;
- ✓ Олон улсын сертификаттай гагнуурчны мэргэжил олгох сургалтад 1 ажилтан
- ✓ „Харилцаа хандлага" сэдэвт сургалтад 8 ажилтан;
- ✓ „Өглөөний менежер" сургалтад 1 ажилтан;
- ✓ „Бизнесийн дижитал хурдасгуур" Chatpot-ийн сургалтад 2 ажилтан тус тус хамрагдав;
- ✓ 15 ажилтан болон удирдлагуудын хамт „Эрдмин' ХХК-ийн үйл ажиллагаатай танилцав.










# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## 2.1. ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2.1.1 "Бат–Илч" ХХК-ийн албан ёсны гэрээт борлуулагч болж EKF болон бусад брэндийн цахилгаан угсралтын бүтээгдэхүүнүүдийг Монгол улсад борлуулах онцгой эрхтэйгээр борлуулж эхэлсэн.







2.1.2 Катодын 99.999% зэс, зэс утас үйлдвэрлэгч Эрдмин ХХК -ийн албан ёсны гэрээт борлуулагчаар хамтран ажиллаж эхэлсэн.









2.1.3 Барилга хот байгуулалтын яам, Орхон аймгийн ЗДТГ хамтран зохион байгуулсан „Дахин төлөвлөн барилгажуулах дэд бүтэцжүүлэх төслүүд“ улсын анхдугаар чуулга уулзалт, зөвлөгөөнд бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулан оролцсон.







2.1.4 „GOLDEN WEEK“ 5 дугаар сарын 13-15-ны хооронд зохион байгуулагдсан Монгол-Японы Бизнес Экспод Япон менежмент, соёлыг нэвтрүүлсний хүрээнд оролцсон.







2.1.5 "Жижиг Дунд Үйлдвэрийн Бүтээгдэхүүн, Үйлчилгээ, Технологи-2022" 5 дугаар сарын 19-22-ны хооронд зохион байгуулагдсан үзэсгэлэнд оролцсон.






## 2.2 ГЭРЭЛТҮҮЛГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

Манай компани 2022 оны стратегийн төлөвлөгөөний дагуу гэрлийн процессыг сайжруулахтай холбоотойгоор өмнөх гэрэл үйлдвэрлэлийн процессуудад хугацааны хэмжилт хийсэн. Энэ хэмжилт нь дараагийн үйлдвэрлэлийн процесст хэрэгтэй чухал үзүүлэлт болно. Мөн энэ шинэчлэлтэй холбоотойгоор шинэ туслах цехүүд үүсгэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд плат өрөх цех, тэжээлийн блок бэлтгэх цех, утас бэлтгэх цех гэсэн 3 цехүүд орно.

Эхний хагас жил буюу 2022.01.01-нээс 2022.06.23 ны хугацаанд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны хураангуйг доорх хүснэгтэд үзүүллээ.

| № | Үйл ажиллагаа | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | ЛЕД гэрэл гэрэлтүүлэг үйлдвэрлэл | ш | **4975** |
| 2 | Гэрэлтүүлгийн шон үйлдвэрлэл | ш | **31** |
| 3 | Үсгэн хаяг | $м^2$ | **23,8** |
| 4 | Щит угсралт | ш | **11** |
| 5 | Гэрээт ажил үйлчилгээ | ш | **2** |

### 2022 оны хагас жилийн гэрэл үйлдвэрлэл

| № | Бүлэг | Нэр | тоо ширхэг | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Гудамжны гэрэл | ASL-3-150W AC220V CW MW саарал | 139 | **379** |
| 2 | | ASL-3-150W AC220V DW MW Саарал | 7 | |
| 3 | | ASL-2-80W AC220V CW JJ | 171 | |
| 4 | | ASL-1-50W AC220V CW JJ | 61 | |
| 5 | | ASL-1-50W AC220V WW JJ | 1 | |
| 6 | Прожектор | AFL-1-50W AC220V DW JJ | 43 | **232** |
| 7 | | AFL-1-50W AC220V WW JJ | 104 | |
| 8 | | AFL-3-150W AC220V DW MW | 22 | |
| 9 | | AFL-3-150W AC220V CW MW | 40 | |
| 10 | | AFL-4-200W AC220V DW MW | 8 | |
| 11 | | AFL-2-100W AC220V DW MW | 15 | |
| 12 | T8, T5 төрлийн гэрлүүд | AT8-1200-36W AC220V CW | 1,030 | **4322** |
| 13 | | AT8-1200-36W AC220V CW V | 15 | |
| 14 | | AT8-1200-36W AC220V P | 118 | |
| 15 | | AT8-1200-36W AC220V WW | 10 | |
| 16 | | AT8-1200-18W AC220V DW | 360 | |
| 17 | | AT8-1200-18W AC220V CW G13 | 2280 | |
| 18 | | AT8-1200-18W AC220V CW | 450 | |
| 19 | | AT8-1200-18W AC220V P | 59 | |
| 20 | Таазны гэрэл | APL-600*600-48W AC220V (ил) | 2 | **35** |
| 21 | | APL-600*600-48W AC220V (далд) | 3 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 22 | | AHB-6-240W AC220V CW MW | 16 | |
| 23 | | AHB-4-160W AC220V CW MW | 2 | |
| 24 | | AHB-1-50W AC220V CW JJ | 12 | |
| 25 | Led чийдэнгууд | AB-70-9W AC220V CW E27 | 7 | **7** |
| Нийт | | | | **4975** |
| 26 | Үсгэн хаяг | Супер маркет мэргэн ресторан | 6.6 | **23.9** |
| 27 | | Ойн генетик нөөцийн "эрдэнэт" төв | 11.5 | |
| 28 | | XII цэцэрлэг | 5.8 | |
| 29 | Шон үйлдвэрлэл | ASLP 12м /цамхаг/ | 6 | **31** |
| 30 | | ASLP1 9м | 21 | |
| 31 | | ASDP1 6м | 4 | |
| 32 | Щит үйлдвэрлэл | Гэрэлтүүлгийн щит 50х40 | 1 | **11** |
| 33 | | Гэрэлтүүлгийн щит 40х30 | 6 | |
| 34 | | Щит 60х50/хувиарлах/ | 4 | |

Шинээр үүсгэгдсэн туслах цехээс Плат өрөх цех **2138ш**, Тэжээлийн блок бэлтгэх цех **2060ш**, Утас бэлтгэх цех **7315ш** тус тус үйлдвэрлэсэн байна. Нийт хагас боловсруулсан бүтээгдэхүүн **11513ш** үйлдвэрлэгдсэн байна.

## 2022 оны 1-р улирлын хагас боловсруулсан бүтээгдэхүүн

| № | | Нэр | Тоо хэмжээ | Нийт |
|---|---|---|---|---|
| 1 | Плат өрөх цех | Өрсөн плат T8-1200-18W CW | 6,331 | 7,406 |
| 2 | | Өрсөн плат T8-1200-18W Pink | 334 | |
| 3 | | Өрсөн плат T8-600-9W CW | 9 | |
| 4 | | Өрсөн плат T8-600-9W WW | 11 | |
| 5 | | Өрсөн плат T8-1200-18W WW | 21 | |
| 6 | | Өрсөн плат D60-9W | 7 | |
| 7 | | Өрсөн плат T8-1200-18W DW | 693 | |
| 8 | Тэжээлийн блок бэлтгэх цех | Бэлдсэн тэжээлийн блок T8 | 1,425 | 7,122 |
| 9 | | Бэлдсэн тэжээлийн блок T8 +/L125+1*0.5mm/ | 3,390 | |
| 10 | | Бэлдсэн тэжээлийн блок T8+ /L125 лапша/ | 2,300 | |
| 11 | | Кембрикдсэн тэжээлийн блок | 7 | |
| 12 | Утас бэлтгэх цех | L20-1*0.5-ХАР /дулаанд тэсвэртэй/ | 7,254 | 22,475 |
| 13 | | L20-1*0.5-УЛААН /дулаанд тэсвэртэй/ | 7,261 | |
| 14 | | L125-1*0.5-ХАР/Эрдмин/ | 3,416 | |
| 15 | | L60-3*1.5-ХАР /газардуулгатай/ | 455 | |
| 16 | | L25-1*0.5-ХАР /дулаанд тэсвэртэй/ | 195 | |
| 17 | | L25-1*0.5-УЛААН /дулаанд тэсвэртэй/ | 195 | |
| 18 | | L35-1*0.5-ХАР /дулаанд тэсвэртэй/ | 233 | |
| 19 | | L45-1*0.5-ХАР /дулаанд тэсвэртэй/ | 275 | |
| 20 | | L35-1*0.5-УЛААН /дулаанд тэсвэртэй/ | 233 | |
| 21 | | L45-1*0.5-УЛААН /дулаанд тэсвэртэй/ | 275 | |
| 22 | | L30-1*0.5-ХАР /дулаанд тэсвэртэй/ | 154 | |
| 23 | | L30-1*0.5-УЛААН /дулаанд тэсвэртэй/ | 154 | |
| 24 | | L125-2*0.5-ЦАГААН/лапша+Эрдмин/ | 2,330 | |
| 25 | | L8.5-1*0.5-ЦАГААН /дулаанд тэсвэртэй/ | 25 | |
| 26 | | L57-1*0.5-ЦАГААН /дулаанд тэсвэртэй/ | 5 | |
| 27 | | L50-3*1.5-ХАР | 15 | |
| Нийт | | | 37,003 | 37,003 |

*График1- хагас жилд  үйлдвэрлэсэн гэрлийн төрлийн эзлэх хувь*




*Үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн болох **4975 ширхэг** гэрлийг 100% гэж үзэн хувиар бодож үзвэл дээрх график дах үзүүлэлт гарч байна. Эндээс T8, T5 төрлийн гэрлүүд / led 2835/ 87% буюу хамгийн их хувийг эзэлжээ. Гудамжны гэрэл 7%, Прожектор 5%, Таазны гэрэл болон үсгэн хаяг хамгийн бага хувийг эзэлсэн байна.*

*График2- 1-р улирлын хагас боловсруулсан бүтээгдэхүүний  төрлийн эзлэх хувь*




*Хагас боловсруулсан бүтээгдэхүүн **37003ш** үйлдвэрлэснээс хамгийн их 61%-г утас бэлтгэх цех, тэжээлийн блок үйлдвэрлэх цех 19%, плат өрөх цех 20% эзэлсэн байна.*

## 2022оны хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын зураг

*Дотор гэрэлтүүлэг- 4364 ш*









*Гадна гэрэлтүүлэг-611ш*











## Булаг багийн гэрэлтүүлгийн ажил









## Эрдэнэт өртөө гэрэлтүүлгийн ажил







Үсгэн хаяг-23,9м2






## 2.3. САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Үзүүлэлт | хэмжих нэгж | 2019 | 2020 | 2021 | 2022 оны 1 хагас жилд |
|---|---|---|---|---|---|
| Гэрлийн жижиглэнгийн борлуулалт | сая.төг | 353 | 489 | 28.7 | 34.6 |
| Гэрлийн бөөний борлуулалт | | | | 318.8 | 205.2 |
| Цахилгаан тоног төхөөрөмж худалдаа | | 238 | 589 | 45.3 | 228.8 |
| Цахилгаан тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт , Автоматжуулалтын ажил | | | | 550.8 | 245.5 |
| Гэрэлтүүлгийн угсралт суурилуулалт | | 0 | 0 | 52.5 | 119.7 |
| Анд-Маркет (хүнс, кофе шоп) | | 0 | 0 | 65.9 | 33 |
| **Нийт борлуулалтын орлого** | | **592** | **1,078** | **1,062** | **866.8** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | сая.төг | 316 | 583 | 671 | 512 |
| Үйл ажиллагааны зардал | | 181 | 368 | 295.8 | 339,1 |
| Цэвэр ашиг | | 55 | 238 | 32.7 | 14,3 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТ** | | | | | |
| Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо | ширхэг | 13,833 | 12,774 | 11,573 | 4975 |
| Борлуулсан бүтээгдэхүүний тоо (үйлдвэрлэн) | | 12,659 | 14,477 | 8,982 | 4933 |
| Үйлдвэрлэлийн хүчин чадал | | 300-500 | 500-800 | 500-800 | 500-800 |
| Ажил | | 11 | 8 | 7 | 5 |
| Цахилгаан тоног төхөөрөмж нийлүүлэлт | | - | 3 | - | 2 |

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД






## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД






## ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ




## ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ



# ГУРАВДУГААР БҮЛЭГ. БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 3.1. MEIYUN LIGHTING БРЕНДИЙН ШИНЭ ЗАГВАРЫН ГЭРЭЛТҮҮЛГИЙН ХУДАЛДАА

Манай компани 2022 оны 03 сарын 20 – ноос эхлэн MEIYUN LIGHTING брендийн гэрлийн бүрхүүлийг үйлдвэрээс нь шууд хэрэглэгчийн гарт хүргэж эхэлсэн.











## 3.2 ГЭРЭЛТҮҮЛГИЙН САЛБАРЫН ТУХАЙ

LED гэрэл гэрэлтүүлгийн үйлдвэрлэл борлуулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй тогтмол өсөж байна. Улайсдаг гэрэлтүүлгээс LED гэрэл цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй байдаг нь байгууллага, өрхийн сонголтод эергээр нөлөөлж байна. 2019 оны мэдээгээр дэлхийн зах зээлийн хувьд 35 орчим тэрбум ам.доллар бөгөөд 2023 онд 45 тэрбум ам.доллар, 2030 онд 84 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгааг судлаачид илэрхийлж байна. 2024 он гэхэд LED гэрэл гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн хэрэгсэл үйлдвэрлэгчид жилдээ 28% -ийн ашиг олно гэж төлөвлөж байна. LED чип үйлдвэрлэгчид Үүнд:

1. Everlight Electronics
2. GYLE
3. Lite-on Technology
4. Mitsubishi
5. Osram
6. Epistar – диод
7. GE
8. Philips зэрэг үйлдвэрлэгчид байна.





Манай компани Epistar брендийн диодыг үйлдвэрлэлдээ ашиглаж байна.

## ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

Манай улсын LED технологи, гэрэл гэрэлтүүлгийн зах зээл импортын бүтээгдэхүүнээс хамааралтай байдаг. Гэрэл гэрэлтүүлгийн зах зээлийн хувьд импортын гэрлийн 90 хувь ньБНХАУ-аас хамааралтай байгаа бөгөөд борлуулалтын дараах сувгуудаар борлуулагдаж байна. Үүнд

- ✓ Барилгын материалын төрөлжсөн худалдааны төв, дэлгүүр
- ✓ Онлайн худалдаа
- ✓ БНХАУ-ын үйлдвэрлэгч нарын төлөөлөгчийн газар, гэрээт дэлгүүр

Гэрэл хэрэглэгч нь байгууллага, хувь хүн бөгөөд дотор, гадна талбайд ашиглаж байна. Манай улсад бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 95,2 мянган аж ахуйнэгж, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан 908,7 мянган өрх гэрэл гэрэлтүүлэгхэрэглэж байна. Эдгээр хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн ашиглалтын хугацаа урттай, орчин үеийн интерьерын шийдэлд тохирсон загвар хийцтэй гэрэл үйлдвэрлэн, борлуулалтын оновчтой суваг сонгон, үр дүнтэй маркетингийн арга хэрэгсэл ашиглан борлуулалтаа нэмэгдүүлэх, зах зээлээ өргөтгөх боломжтой юм.

## 3.3 БҮТЭЭГДЭХҮҮН



LED Чийдэн
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 5Вт, 7Вт, 9Вт, 12Вт
Цагаан, шар туяатай



LED Нүдэн гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 3Вт, 5Вт
Бүрхүүлийн сонголттой

LED Candle гэрэл /Абжурны/
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 5Вт
Гадна бүрхүүлийн сонголттой



LED Нүдэн гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 3Вт, 5Вт
Гадна бүрхүүлийн сонголттой





LED Прожектор
Зориулалт: Гадна гэрэлтүүлэг
Чадал: 50Вт, 100Вт, 150Вт
Хүчдэл: 85-265В



LED Тумпэн гэрэл
Зориулалт: Үйлдвэрийн /IP65/
Чадал: 50Вт, 100Вт, 150Вт
Хүчдэл: 85-265В

LED T8 төрлийн суурьтай гэрэл
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 9Вт, 18Вт, 36Вт
Хүчдэл: 85-265В



LED T8 төрлийн суурьгүй гэрэл
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 9Вт, 18Вт, 22Вт
Хүчдэл: 85-265В





LED Толгой гэрэл
Зориулалт: Гадна гэрэлтүүлэг
Чадал: 120Вт, 150Вт, 180Вт
Хүчдэл: 85-265В



LED Толгой гэрэл
Зориулалт: Гадна гэрэлтүүлэг
Чадал: 50Вт, 60Вт, 80Вт, 100Вт
Хүчдэл: 85-265В

LED таазны гэрэл /C32/
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 32Вт
Хүчдэл: 85-265В



LED Таазны гэрэл /Панел/
Зориулалт: Дотор гэрэлтүүлэг
Чадал: 48Вт
Хүчдэл: 85-265В





LED Малчны гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 10Вт
Туяаны /өнгө/ сонголттой
Хүчдэл: Тогтмол 12В



LED Аялалын гэрэл
Зориулалт: Ахуйн хэрэглээний
Чадал: 3Вт
Хүчдэл: Тогтмол 5В

## 3.4 БИДНИЙ ХАРИЛЦАГЧИД

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## 4.1 ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

"Анд-Энерги" ХК нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын сонирхлын тэнцвэрийг хангах, компанийн үйл ажиллагааны бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэгдсэн дараах засаглалын бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.




Манай компани Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, гадны компаниудын сайн засаглалын туршлагаас суралцан Сайн засаглалыг нэвтрүүлэх, компанийн засаглалаар манлайлахаар чармайн ажиллаж ирсэн бөгөөд Компанийн засаглалыг хөгжүүлэх ажлын хүрээнд Монголын хувьцаат компаниудын холбоо ТББ-ийн гишүүнээр элсэн харилцан туршлага солилцон ажиллаж байна.

*Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах журмуудыг мөрдөн ажиллаж байна.*

- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
- ✓ Аудитын хорооны журам
- ✓ Нэр дэвшүүлэх хорооны журмыг шинэчлэн батлах
- ✓ Цалин, урамшууллын хорооны журмыг батлах
- ✓ Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах журам батлах
- ✓ Мэдээллийн үйл ажиллагааны журам.

## 4.2 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:




НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО
***78 070 758***

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО
***580***

/2022.04.04-ны өдрийн байдлаар/

## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Эзэмшигчийн хувь |
|---|---|---|---|
| 1 | Т.Барс | 12 881 675 | 16.5% |
| 2 | Ц.Гүррагчаа | 12 881 675 | 16.4% |
| 3 | Д.Мөнхбаяр | 12 881 675 | 16.5% |
| 4 | Г.Түвшин | 12 881 675 | 16.5% |

## 4.3 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ:

„Анд-Энерги" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 сарын 23-ны өдөр компанийн албан ёсны пэйж хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр нээлттэй зохион байгуулав. Хуралд „Анд-Энерги" ХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комисс болон тус компанийн 24 хувьцаа эзэмшигчид оролцлоо.

2022 оны 4 сарын 4-ний хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн байдлаар нийт 580 хувьцаа эзэмшигчид „Анд-Энерги" ХК-ийн 78,070,758 ширхэг хувьцааг эзэмшиж байгаагаас тус ээлжит хуралд 67.82% буюу 52,944,700 ширхэг хувьцааг эзэмшдэг 24 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болов.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлуудыг дараалын дагуу танилцуулж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга болон асуулт хариулт, санал хураалтын үйл ажиллагаа явагдсанаар дараах шийдвэр гарсан. Үүнд:

1. Анд-Энерги ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.
2. Анд-Энерги ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Хараат бус аудитын тайлан дүгнэлтийг „Хангалттай" үнэлгээгээр батлав.
3. Анд-Энерги ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн **ердийн** гишүүдэд

    1. Далхаа овогтой Мөнхбаяр
    2. Төмөрбат овогтой Барс
    3. Ганхуяг овогтой Түвшин
    4. Цэнд-Аюуш овогтой Гүррагчаа
    5. Дагвапунцаг овогтой Алтангэрэл
    6. Эрдэнэбаяр овогтой Мягмардорж

Төлөөлөн удирдах зөвлөлийн **Хараат бус** гишүүдэд

1. Мөнхжаргал овогтой Ганбат
2. Дуусүрэн овогтой Мөнхбат
3. Дашдаваа овогтой Боргио нарыг тус тус

2022 оны 4 сарын 23-ны өдрөөс эхлэн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгов.








## 4.4 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах ердийн болон хараат бус гишүүд шинээр сонгогдож, 2022 оны 5 дугаар сараас эхлэн доорх шинэчилсэн баг бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Төмөрбат
**БАРС**

ТУЗ-ийн дарга
/Аудитын хорооны гишүүн/



Далхаа
**МӨНХБАЯР**

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Цалин урамшууллын хорооны гишүүн/



Ганхуяг
**ТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

„Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ
Автоматикийн ахлах инженер



Цэнд-Аюуш
**ГҮРРАГЧАА**

ТУЗ-ийн ердийн гишүүн

„Анд-Энерги" ХК
Гүйцэтгэх захирал



Эрдэнэбаяр
**МЯГМАРДОРЖ**

ТУЗ-ийн ердийн гишүүн
/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

Өмгөөлөгч



Дагвапунцаг
**АЛТАНГЭРЭЛ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

„АЦХ" ХХК
Гүйцэтгэх захирал



Мөнхжаргал
**ГАНБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Аудитын хорооны гишүүн/
/Цалин урамшууллын хорооны дарга/

Орхон аймаг дахь Худалдаа Аж
Үйлдвэрийн танхимын дарга



Дашдаваа
**БОРГИО**

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Нэр дэвшүүлэх хорооны дарга/
/Цалин урамшууллын хорооны гишүүн/



Дүүсүрэн
**МӨНХБАТ**

ТУЗ-ийн хараат бус гишүүн
/Аудитын хорооны дарга/
/Нэр дэвшүүлэх хорооны гишүүн/

Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт олон улсын байгууллагын ногоон хотын асуудал хариуцсан мэргэжилтэн

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХОРООД:

### *НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО*

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг

тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр Эрдэнэбаяр овогтой Мягмардорж, Дүүсүрэн овогтой Мөнхбат, хорооны даргаар Дашдаваа овогтой Боргио нар тус тус сонгогдон ажиллаж байна.

## ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Цалин урамшууллын хорооны гишүүдээр Дашдаваа овогтой Боргио, Далхаа овогтой Мөнхбаяр, хорооны даргаар Мөнхжаргал овогтой Ганбат нар тус тус сонгогдон ажиллаж байна.

## АУДИТЫН ХОРОО

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Аудитын хорооны гишүүдээр Төмөрбат овогтой Барс, Мөнхжаргал овогтой Ганбат, хорооны даргаар Дүүсүрэн овогтой Мөнхбат нар тус тус сонгогдон ажиллаж байна.

2022 оны 2-р улиралд Аудитын хороо нэг удаа хуралдаж санхүүгийн 1-р улирлын тайланд дүгнэлт өгч ажилласан байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧИГ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн ээлжит бус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Б.Тогос-Эрдэнийг үргэлжлүүлэн томилон ажиллуулахаар шийдвэрлэсэн.



Батцэрэн
**ТОГОС-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

„Анд-Энерги" ХК
Хүний нөөцийн менежер

## 4.5 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны эхний хагас жилд нийт 5 удаа хуралдаж, 15 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, ТУЗ-ийн 15 тогтоол гарган компанийн үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажилласан байна

| № | Хуралдсан огноо | Хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд | Тогтоолын дугаар |
|---|---|---|---|
| 1 | 2022.02.16 (ээлжит хурал) | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөг батлав.<br>- Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу идэвх санаачилгатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов. | 22/01 |
| 2 | | Компанийн 2021 оны үйл ажиллагааны ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.<br>- Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн энэхүү тогтоолын үндэслэлийг 2022 оны 04 дүгээр сард болох Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар тогтов. | 22/02 |
| 3 | 2022.03.02 (ээлжит бус хурал) | „Анд-Энерги" ХК-ийн 2022 оны бизнес төлөвлөгөөг батлав.<br>- Батлагдсан төлөвлөгөөг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж, үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах талаар арга хэмжээ авах, компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаад үүрэг болгов. | 22/03 |
| 4 | | Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөв.<br>- „Анд-Энерги" ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг „Хангалттай" хэмээн дүгнэв.<br>„Анд-Энерги" ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг өөртөө үлдээв. | 22/04 |
| 5 | | Улсын бүртгэлийн гэрчилгээнд залруулах бичилт хийлгэх зөвшөөрөл олгов.<br>- „Анд-Энерги" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд доорх өөрчлөлтүүдийг тусган дахин гэрчилгээ авахыг Гүйцэтгэх захирал Ц. Гүррагчаад даалгав. | 22/05 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | 2022.03.12 (ээлжит бус хурал) | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 2-ны өдрийн 14:00 цагт Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, 3-4,6 тоотод байрлах өөрийн байранд цахим хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэв.<br>- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Мөнхбаяр, Хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэ, гишүүдээр ТУЗ-ийн гишүүн Т.Барс, М.Ганбат, Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаа, Маркетингийн менежер М.Дэлгэрмаа, Тооллогын комиссын даргаар тооцооны нягтлан бодогч Д.Ундармаа, гишүүдээр Бичиг хэргийн ажилтан А.Байгальмаа, Үйлдвэрлэлийн менежер А.Алтансүх нарыг тус тус томилов. | 22/06 |
| 7 | 2022.05.15 (ээлжит хурал) | „Анд-Энерги" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа дууссан тул Далхаа овогтой Мөнхбаярыг ТУЗ-ийн даргын албан тушаалаас чөлөөлөв.<br>- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Төмөрбат овогтой Барсыг 2022 оны 5 сарын 15-ны өдрөөс томилов.<br>- 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн дотор ажлыг хүлээлцэх ажлыг зохион байгуулахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тогос-Эрдэнэд үүрэг болгов. | 22/07 |
| 8 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороодыг тус тус байгуулав.<br>- Аудитын хорооны гишүүдээр Төмөрбат овогтой Барс, Мөнхжаргал овогтой Ганбат, хорооны даргаар Дүүсүрэн овогтой Мөнхбат нарыг тус тус томилов.<br>- Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр Эрдэнэбаяр овогтой Мягмардорж, Дүүсүрэн овогтой Мөнхбат, хорооны даргаар Дашдаваа овогтой Боргио нарыг тус тус томилов.<br>- Цалин урамшууллын хорооны гишүүдээр Дашдаваа овогтой Боргио, Далхаа овогтой Мөнхбаяр, хорооны даргаар Мөнхжаргал овогтой Ганбат нарыг тус тус томилов. | 22/08 |
| 9 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг 73.900.000 (Далан гурван сая есөн зуун мянга)-н төгрөгөөр, зардлын төсвийн задаргааг хавсралтаар батлав. | 22/09 |
| 10 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Батцэрэн овогтой Тогос-Эрдэнийг үргэлжлүүлэн томилон ажиллуулахаар шийдвэрлэв.<br>- ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалинг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсөвт тусгагдсаны дагуу олгохыг Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаад даалгав. | 22/10 |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | | „Анд-Энерги“ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар хагас жилийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар шинэчлэн батлав.<br>- Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу идэвх санаачилгатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов. | 22/11 |
| 12 | 2022.06.22 (ээлжит бус хурал) | Анд-Энерги“ ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Цэнд-Аюуш овогтой Гүррагчааг нэг жилийн хугацаатай улираан томилов.<br>- Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох, дүрэм журам боловсруулахыг Нэр дэвшүүлэх хорооны дарга /Д.Боргио/, Цалин урамшууллын хорооны дарга /М.Ганбат/ нарт тус тус даалгав.<br>- Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаатай холбогдох журмын дагуу гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Т.Барс/-д даалгав. | 22/12 |
| 13 | | „Эрдэнэт үйлдвэр“ ТӨҮГ-тай 2022.06.20-ны өдөр байгуулсан 07/052-22 тоот гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор Худалдаа хөгжлийн банкнаас 215,000,000 (Хоёр зуун арван таван сая) төгрөгийн эх үүсвэргүй урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулахыг зөвшөөрөв.<br>- Уг зээлийн барьцаанд „Анд-Энерги“ ХК-ийн өмчлөлийн Улсын бүртгэлийн Ү-2101022768 дугаар бүхий Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртын гол баг, Баян-Замын 3-4 тоотод байрлах 1038,5 м2 талбайтай үйлдвэрийн барилга, Уртын гол баг, Баян-Замын 3-4 тоот, үйлдвэрлэлийн зориулалт бүхий 1020 м2 газрыг (нэгж талбарын дугаар 6105101223) тус тус үргэлжлүүлэн барьцаалуулахыг зөвшөөрөв.<br>- Худалдаа хөгжлийн банкнаас 215,000,000 (Хоёр зуун арван таван сая) төгрөгийн эх үүсвэргүй урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулахтай холбоотой гэрээ хэлцэл хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаад олгов. | 22/13 |
| 14 | | „Анд-Энерги“ ХК-ийн эзэмшлийн Toyota Axio маркийн тээврийн хэрэгслийг санхүүгийн балансд бүртгэлтэй үнэ болох 9.376.600 (Есөн сая гурван зуун далан зургаан мянга зургаан зуу)-н төгрөг байхыг зөвшөөрөв.<br>- Компанийн Toyota Axio тээврийн хэрэгслийг санхүүгийн балансд бүртгэлтэй үнийн дүнг бууруулахгүйгээр зарж борлуулах эсвэл бартер хийх эрхийг Гүйцэтгэх захирал Ц.Гүррагчаад олгов. | 22/14 |
| 15 | | Анд-Энерги“ ХК-ийн санхүүгийн баланс дээр бүртгэлттэй хоёр барилга (ажилчдын байр, узелийн байр)-ыг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхийг зөвшөөрөв.<br>- Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ц. Гүррагчаад даалгав. | 22/15 |

## 4.6 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ХУВЬЦААНЫ ҮНЭ :

| № | Мэдээллийн төрөл | Огноо | |
|---|---|---|---|
| | | 2021.06 | 2022.06 |
| 1 | Гаргасан хувьцааны тоо | 78 070 758 | |
| 2 | Компанийн зах зээлийн нийт үнэлгээ (төгрөгөөр) | 3 122 830 320 ₮ | 2 264 051 982 ₮ |
| 3 | Арилжааны дүн (төгрөгөөр) | 740 000 ₮ | 5 905 600 ₮ |
| 4 | Арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг | 18 500 | 151 300 |
| 5 | Дээд үнэ | 40 ₮ | 57 ₮ |
| 6 | Доод үнэ | 40 ₮ | 26 ₮ |
| 7 | Дундаж үнэ | 40 ₮ | 35.9 ₮ |
| 8 | Хаалтын үнэ (06 сарын 30-ний байдлаар) | 40 ₮ | 29 ₮ |

### ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТАЙЛАН МЭДЭЭ :_ /2022.01.01-2022.06.30/

| № | Үнэт цаасны компанийн нэр | Арилжааны дүн (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1 | „Ард Секюритиз ҮЦК" ХХК | 8,918,900 ₮ |
| 2 | „Бумбат Алтай ҮЦК" ХХК | 1,380,300 ₮ |
| 3 | „Дэлгэрхангай Секюритиз" ХХК | 1,512,000 ₮ |

# ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 5.1 САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хэвлэсэн : 2022/07/08 07:20:00

**Санхүүгийн байдлын тайлан /А/**

АНД ЭНЕРГИ ХК

Тайлант үе : 2022.01.01 - 2022.06.30

/ төгрөгөөр /

| | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1.** | **Хөрөнгө** | | |
| **1.1.** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1. | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 13,288,511.33 | 4,338,389.42 |
| 1.1.2. | Дансны авлага | 299,802,716.70 | 461,128,787.42 |
| 1.1.3. | Татвар, НДШ–ийн авлага | 488,283.00 | - |
| 1.1.4. | Бусад авлага | 2,481,536.95 | 30,679,686.00 |
| 1.1.5. | Бусад санхүүгийн хөрөнгө | - | - |
| 1.1.6. | Бараа материал | 349,216,729.55 | 431,527,165.43 |
| 1.1.7. | Урьдчилж төлсөн зардал / тооцоо | 214,732,737.56 | 64,112,182.19 |
| 1.1.8. | Бусад эргэлтийн хөрөнгө | - | - |
| 1.1.9. | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **1.1.10.** | **Эргэлтийн хөрөнгийн нийт дүн** | **880,010,515.09** | **991,786,210.46** |
| **1.2.** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1. | Үндсэн хөрөнгө | 1,667,908,733.11 | 1,624,175,019.13 |
| 1.2.2. | Биет бус хөрөнгө | 67,220,278.84 | 66,074,405.83 |
| 1.2.3. | Биологийн хөрөнгө | 6,500,000.00 | 6,500,000.00 |
| 1.2.4. | Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | - |
| 1.2.5. | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | - | - |
| 1.2.6. | Хойшлогдсон татварын хөрөнгө | - | - |
| 1.2.7. | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | - |
| 1.2.8. | Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - |
| **1.2.9.** | **Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн** | **1,741,629,011.95** | **1,696,749,424.96** |
| **1.3.** | **Хөрөнгийн нийт дүн** | **2,621,639,527.04** | **2,688,535,635.42** |
| **2.** | **Өр төлбөр ба эздийн өмч** | | |
| **2.1.** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1.** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1. | Дансны өглөг | 24,070,127.08 | 14,895,657.08 |
| 2.1.1.2. | Цалингийн өглөг | - | 17,068,613.36 |
| 2.1.1.3. | Татварын өр | 19,185,426.28 | 56,197,477.20 |
| 2.1.1.4. | НДШ-ийн өглөг | 26,249,420.95 | 15,882,563.89 |
| 2.1.1.5. | Богино хугацаат зээл | 51,247,472.37 | 172,489,115.00 |
| 2.1.1.6. | Хүүний өглөг | 434,036.86 | - |
| 2.1.1.7. | Ногдол ашгийн өглөг | - | - |
| 2.1.1.8. | Урьдчилж орсон орлого | 22,486,520.00 | 1,320,000.00 |
| 2.1.1.9. | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.1.10. | Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| 2.1.1.11. | Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд | - | - |
| **2.1.1.12.** | **Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн** | **143,673,003.54** | **277,853,426.53** |

1/2

| Тайлангийн үзүүлэлт | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **2.1.2.** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1. | Урт хугацаат зээл | 406,213,991.47 | 324,551,165.52 |
| 2.1.2.2. | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.2.3. | Хойшлогдсон татварын өр | - | - |
| 2.1.2.4. | Бусад урт хугацаат өр төлбөр | - | - |
| **2.1.2.5.** | **Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн** | **406,213,991.47** | **324,551,165.52** |
| **2.2.** | **Өр төлбөрийн нийт дүн** | **549,886,995.01** | **602,404,592.05** |
| **2.3.** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1. | Өмч -төрийн | - | - |
| 2.3.2. | Өмч -хувийн | 78,070,758.00 | 78,070,758.00 |
| 2.3.3. | Өмч -хувьцаат | - | - |
| 2.3.4. | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5. | Нэмж төлөгдсөн капитал | 1,470,540,877.00 | 1,470,540,877.00 |
| 2.3.6. | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 264,224,371.82 | 264,224,371.82 |
| 2.3.7. | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8. | Эздийн өмчийн бусад хэсэг | - | - |
| 2.3.9. | Хуримтлагдсан ашиг | 258,916,525.21 | 273,295,036.55 |
| **2.3.10.** | **Эздийн өмчийн нийт дүн** | **2,071,752,532.03** | **2,086,131,043.37** |
| **2.4.** | **Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн** | **2,621,639,527.04** | **2,688,535,635.42** |

Захирал ........ / Ц.Гүррагчаа /

Ерөнхий нябо ........ / Ч.Саранзаяа /

2/2

## 5.2 ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Хэвлэсэн : 2022/07/08 07:22:43

### Орлогын дэлгэрэнгүй тайлан /Б/

АНД ЭНЕРГИ ХК

Тайлант үе : 2022.01.01 - 2022.06.30

/ төгрөгөөр /

| | Тайлангийн үзүүлэлт | Тайлант үеийн дүн |
|---|---|---|
| 1. | Борлуулалтын орлого (цэвэр) | 866,759,622.24 |
| 2. | Борлуулалтын өртөг | 512,022,488.00 |
| | **Нийт ашиг (алдагдал)** | **354,737,134.24** |
| 4. | Түрээсийн орлого | - |
| 5. | Хүүний орлого | - |
| 6. | Ногдол ашгийн орлого | - |
| 7. | Эрхийн шимтгэлийн орлого | - |
| 8. | Бусад орлого | 44,850.07 |
| 9. | Борлуулалт, маркетингийн зардал | 66,265,662.77 |
| 10. | Ерөнхий ба удирдлагын зардал | 238,937,295.64 |
| 11. | Санхүүгийн зардал | 29,425,459.02 |
| 12. | Бусад зардал | 4,457,980.39 |
| 13. | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 1,218.92 |
| 14. | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 279,318.30 |
| 15. | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - |
| 16. | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - |
| 17. | Бусад ашиг (алдагдал) | - |
| | **Татварын өмнөх ашиг (алдагдал)** | **15,976,123.71** |
| 19. | Орлогын татварын зардал | 1,597,612.37 |
| | **Татварын дараахь ашиг (алдагдал)** | **14,378,511.34** |
| 21. | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - |
| | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **14,378,511.34** |
| | **Бусад дэлгэрэнгүй орлого** | - |
| 23.1. | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - |
| 23.2. | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - |
| 23.3. | Бусад олз (гарз) | - |
| | **Орлогын нийт дүн** | **14,378,511.34** |
| 25. | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - |

Захирал / Ц.Гүррагчаа /

Ерөнхий нябо / Ч.Саранзаяа /

1/1

## 5.3 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хэвлэсэн : 2022/07/08

**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

АНД ЭНЕРГИ ХК

Тайлант үе : 2022.01.31 - 2022.06.30

/ төгрөгөөр /

| Тайлангийн үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12 сарын 31-ны үлдэгдэл** | **78,070,758.00** | - | **1,470,540,877.00** | **264,224,371.82** | - | - | **279,569,146.26** | **2,092,405,153.08** |
| 1. Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, алдааны залруулга | - | - | - | - | - | - | -34,534,443.32 | **-34,534,443.32** |
| **Залруулсан үлдэгдэл** | **78,070,758.00** | - | **1,470,540,877.00** | **264,224,371.82** | - | - | **245,034,702.94** | **2,057,870,709.76** |
| 2. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | - | 13,881,822.27 | **13,881,822.27** |
| 3. Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - | - | - |
| 4. Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - | - | - |
| 5. Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - | - | - |
| 6. Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - | - |
| **2022 оны 1 сарын 30-ны үлдэгдэл** | **78,070,758.00** | - | **1,470,540,877.00** | **264,224,371.82** | - | - | **258,916,525.21** | **2,071,752,532.03** |
| 1. Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, алдааны залруулга | - | - | - | - | - | - | - | - |
| **Залруулсан үлдэгдэл** | **78,070,758.00** | - | **1,470,540,877.00** | **264,224,371.82** | - | - | **258,916,525.21** | **2,071,752,532.03** |
| 2. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | - | 14,378,511.34 | **14,378,511.34** |
| 3. Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - | - | - |
| 4. Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - | - | - | - | - |
| 5. Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | - | - | - |
| 6. Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | - | - | - |
| **2022 оны 6 сарын 29-ны үлдэгдэл** | **78,070,758.00** | - | **1,470,540,877.00** | **264,224,371.82** | - | - | **273,295,036.55** | **2,086,131,043.37** |

/ Ц.Гүррагчаа /　　　　　/ Ч.Саранзаяа /

1/1

## 5.4 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хэвлэсэн : 2022/07/08 07:31:22

**Мөнгөн гүйлгээний тайлан /А/**

2022.01.01 - 2022.06.30 | АНД ЭНЕРГИ ХК | / төгрөгөөр /

| Тайлангийн үзүүлэлт | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | **116,864,931.25** | **-52,226,223.05** |
| **Мөнгөн орлогын дүн** | | **4,659,436,453.29** | **852,169,527.94** |
| 1.1.1. | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 3,723,644,121.97 | 692,233,218.90 |
| 1.1.2. | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| 1.1.3. | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | - | - |
| 1.1.4. | Буцаан авсан албан татвар | - | - |
| 1.1.5. | Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| 1.1.6. | Бусад мөнгөн орлого | 935,792,331.32 | 159,936,309.04 |
| **Мөнгөн зарлагын дүн** | | **4,542,571,522.04** | **904,395,750.99** |
| 1.2.1. | Ажиллагчдад төлсөн | 581,583,910.91 | 106,051,311.57 |
| 1.2.2. | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 140,848,444.98 | 58,388,604.65 |
| 1.2.3. | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,620,561,562.74 | 404,800,524.98 |
| 1.2.4. | Ашиглалтын зардалд төлсөн | 15,205,017.29 | 747,071.00 |
| 1.2.5. | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 34,668,505.88 | 7,006,478.27 |
| 1.2.6. | Хүүний төлбөрт төлсөн | 177,297,877.36 | 29,425,459.02 |
| 1.2.7. | Татварын байгууллагад төлсөн | 403,262,746.26 | 35,551,304.19 |
| 1.2.8. | Даатгалын төлбөрт төлсөн | 1,256,910.00 | - |
| 1.2.9. | Бусад мөнгөн зарлага | 567,886,546.62 | 262,424,997.31 |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | **-101,907,664.81** | **-78,107,112.16** |
| **Мөнгөн орлогын дүн** | | **7,310,914.09** | **4,460,495.00** |
| 2.1.1. | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 7,000,000.00 | 4,460,495.00 |
| 2.1.2. | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.3. | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| 2.1.4. | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| 2.1.5. | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| 2.1.6. | Хүлээн авсан хүүний орлого | 310,914.09 | - |
| 2.1.7. | Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| **Мөнгөн зарлагын дүн** | | **109,218,578.90** | **82,567,607.16** |
| 2.2.1. | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 14,285,000.00 | - |
| 2.2.2. | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 4,232,224.00 | - |
| 2.2.3. | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.4. | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| 2.2.5. | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 90,701,354.90 | 82,567,607.16 |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | **-48,191,444.10** | **121,383,213.30** |
| **Мөнгөн орлогын дүн** | | **1,278,346,910.18** | **338,862,223.16** |
| 3.1.1. | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 1,278,346,910.18 | 338,862,223.16 |
| 3.1.2. | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн | - | - |
| 3.1.3. | Төрөл бүрийн хандив | - | - |
| **Мөнгөн зарлагын дүн** | | **1,326,538,354.28** | **217,479,009.86** |
| 3.2.1. | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 1,242,221,935.28 | 217,479,009.86 |
| 3.2.2. | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | - |
| 3.2.3. | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | - |
| 3.2.4. | Төлсөн ногдол ашиг | 84,316,419.00 | - |
| **ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮ** | | - | - |
| **БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | **-33,234,177.66** | **-8,950,121.91** |
| **МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | | **25,658,954.22** | **13,288,511.33** |
| **МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | | **13,288,511.33** | **4,338,389.42** |
| | БЦМГ /1,3+2,3+3,3+4/ | -33,234,177.66 | -8,950,121.91 |
| | БЦМГ /6-5/ | -12,370,442.89 | -8,950,121.91 |
| | Зөрүү | 20,863,734.77 | - |

АНД ЭНЕРГИ ХК

Захирал ................ / Ц.Гүррагчаа /

Ерөнхий нябо ................ / Ч.Саранзаяа /


Гэрэлтэй амьдарцгаая
АНД-ЭНЕРГИ ХК
Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Уртын гол баг, Баян-Зам 3, 4-6 тоот
Утас: 77711010, 95101020
И-мэйл: Info.andenergy@gmail.com
Вэб сайт: www.andenergy.mn
Фэйсбүүк: And energy